



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээх зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.4, 6.4.4, 6.4.6, 6.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 11,731,310.00 (арван нэгэн сая долоон зуун гучин нэгэн мянга гурван зуун арав) төгрөгийн балансын үнэ, 2,723,339.97 (хоёр сая долоон зуун хорин гурван мянга гурван зуун гучин есөн төгрөг ерэн долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан авто грашийн барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Д.Зүмбэрэллхам, Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын дарга Ц.Эрдэнэцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах эсхүл хоёрдогч түүхий эд болгон ашиглах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д. Нарангэрэл*

Д.НАРАНГЭРЭЛ

132003420  
25-r\_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 10 дугаар сарын... өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Дахин үнэлгээ хийсэн огноо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуриятлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Автомашини граш	м2	80	2002	2018	11,731,310.00	11,731,310.00	2,723,339.27	9,007,970.73
	Нийт үнэ	м2	80				11,731,310.00 (арван нэгэн сая долоон зуун гурван нэгэн мянга гурван зуун арав)	2,723,339.27 (хоёр сая долоон зуун хорин гурван мянга гурван зуун гучин есөн төгрөг ерэн долоон мөнгө)	9,007,970.73 (есөн сая долоон мянга есөн зуун далан төгрөг далан гурван мөнгө)